



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК




ТӨВ БАНК ЮУ ХИЙДЭГ ВЭ?

Улаанбаатар хот


2022 он




ТӨВ БАНК ОЛОН УЛСАД

 1668 Швед (Riksbank)-Анхны Төв банк



 1934 Шинэ Зеланд (Reserve Bank of NZ)




 1957 Герман (Bundesbank)



 1694 Англи (Bank of England)



 1882 Япон (Bank of Japan)



 1913 Америк (FED)





Дэлхийн олонх улс орон эдийн засаг, санхүүгийн тогтолцоогоо тогтвортой байхад тус болно гэж үзээд Төв банк хэмээх институцийг чухалчилж, үйл ажиллагааг нь дэмжиж ирсэн. Ингэхдээ Төв банкныхаа гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааны нь чиглэлийг хуулиар тусгайлан зохицуулж иржээ. Өнөө үед хөгжлөөрөө тэргүүлэгч улс орнуудын Төв банкууд үнийн тогтвортой байдлыг урт хугацаанд хадгалахыг үндсэн зорилтоо болгож байна.

МОНГОЛБАНК /ТӨВ БАНК/

Монголын Төв банк /Монголбанк/-ны товч түүх











Иргэд арилжааны банкинд хандаж үйлчлүүлдэг учраас Төв банкны нэрийг мэдэхээс цаашгүй, Төв банк юу хийж, ямар үйл ажиллагаа явуулдгийг төдийлөн сонирхдоггүй, ойлголт ч багатай байдаг.

1924 оны 6 дугаар сарын 2-нд Монгол, Зөвлөлт Орос улсын хувь нийлүүлсэн хөрөнгөөр Монголын Худалдаа, аж үйлдвэрийн банк байгуулагджээ. Анх нээгдэхдээ 260 мянган янчааны хөрөнгөтэй, 22 орон тоотой, тэдний 18 нь Зөвлөлтийн мэргэжилтэн, 4 нь монгол ажилтан байжээ. Энэ бол Монголбанкны үүслийн суурийг тавьсан түүхт үйл явдал байв.





Он цагийн хэлхээс (Монголбанк)

-  1260 - Манай улс дэлхийд анх удаа цаасан мөнгө гаргасан
-  1924 - Худалдаа Аж Үйлдвэрийн Банк байгуулагдсан
-  1925 - Үндэсний валютыг төгрөгөөр тогтоосон
-  1926 - Цагаан мөнгөн зоос анх гүйлгээнд гаргасан
-  1931 - Урт хугацаатай зээл өгч эхэлсэн
-  1940 - Улсын төсөв Монголбанкаар дамжих болсон
-  1946 - Зээлийн барьцаа эхэлсэн
-  1954 - Монголбанк Монгол улсын Засгийн газрын мэдэлд бүрэн шилжсэн
-  1963 - Монгол улс олон талт тооцооны системд шилжсэн
-  1991 - 2 шатлалт банкны тогтолцоог нэвтрүүлсэн.

Төв банк, арилжааны банкны ялгаа







Төв банк, арилжааны банкны ялгаа

Улс төр, нийгэм, эдийн засгийн эрс шинэтгэл хийсэн 1990 онд "Аж ахуйн банк байгуулах болон түүний үйл ажиллагааны нийтлэг дүрэм", 1991 онд "Банкны тухай хууль" батлагдсанаар Монгол Улсад 2 шатлалт банкны тогтолцооны хөрс суурийг тавьсан байдаг.








Тэгвэл өдгөө 2022 оны байдлаар Монгол улсад арилжааны 11 банк үйл ажиллагаа явуулж байгаагийн дотор төрийн өмчийн /Төрийн банк/ нэг банк, мөн үүн дээр Монгол Улсын Хөгжлийн банк нэмэгддэг юм. Төв банк болон арилжааны банкны эрхэлж буй үйл ажиллагаа, зорилго өөр хоорондоо ихээхэн ялгаатай, тэдгээрийн заримыг дурдъя.



Арилжааны банк

-  Ашгийн төлөө
-  Мөнгөн тэмдэгт хэвлэж, гүйлгээнд гаргах эрхгүй, мөнгөний бодлого боловсруулахгүй
-  Иргэд, аж ахуйн нэгжээс харилцах, хадгаламж татан төвлөрүүлдэг
-  Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад богино, дунд хугацааны зээл олгодог
-  Банк хоорондын төлбөр тооцоог зохицуулах эрхгүй
-  Үйл ажиллагаагаа хувь (хувьцаа) эзэмшигчдийн өмнө тайлагнадаг

Монголбанк

-  Ашгийн бус
-  Төрөөс үүсгэн байгуулсан
-  Мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргадаг, мөнгөний бодлогыг боловсруулж хэрэгжүүлдэг
-  Харилцах дансны эзэмшигчид нь банкууд, Төрийн сангийн нэгдсэн дансын эзэмшигч нь Засгийн газар байдаг
-  Шаардлагатай тохиолдолд Монголбанкнаас арилжааны банкууд болон Засгийн газарт зээл олгодог
-  Банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулна
-  Үйл ажиллагаагаа УИХ-ын өмнө тайлагнадаг



Төв банкны үндсэн зорилт



Аливаа улс оронд Төв банк юу хийх ёстойг хуулиар тусгайлан зааж өгдөг. Монголбанкны үндсэн зорилтыг Төв банкны тухай хуулийн 4-р зүйлд дараах байдлаар томъёолсон байна. Үүнд:

1. Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.
2. Монголбанк өөрийн үндсэн зорилтын хүрээнд санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах замаар үндэсний эдийн засгийн тэнцвэртэй хөгжилд дэмжлэг үзүүлнэ.

Өөрөөр хэлбэл, Монголбанк нь нэн тэргүүнд инфляцыг нам, тогтвортой түвшинд хадгалахын төлөө зорьж ажиллах ёстой. Энэхүү зорилготойгоо нийцтэйгээр Монголын банк, санхүүгийн тогтолцоог мөн тогтвортой байлгах үүргийг хүлээдэг гэж ойлгож болох юм. Харин Монгол Улсын Засгийн газар нь төсвийн, ажил эрхлэлт, гадаад худалдаа г.м. эдийн засгийн өсөлтийг хангах бусад макро эдийн засгийн бодлогуудыг тодорхойлж, хэрэгжүүлдэг.



Монголбанк юу хийдэг вэ?

"Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд зааснаар" өөрийн зорилтыг биелүүлэхийн тулд дараах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлнэ.

Мөнгөний бодлого
боловсруулж, хэрэгжүүлэх



Мөнгөн тэмдэгт гүйлгээнд
гаргах, зохицуулах

Засгийн газрын санхүүгийн
зуучлагчийн үүрэг гүйцэтгэх



Банк болон хуульд тусгайлан
заасан этгээдийн үйл
ажиллагаанд хяналт тавих

Үндэсний төлбөрийн систем,
түүний үйл ажиллагааг
удирдан зохион байгуулах



Гадаад валютын улсын
нөөцийг эзэмших, удирдах

Банкны харилцагч,
хадгаламж эзэмшигчийн
эрх ашгийг хамгаалах



Макро зохистой бодлого
хэрэгжүүлэх

/2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

1. Мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах

1. Монгол Улсын мөнгөн тэмдэгтийн албан ёсны нэгж нь төгрөг мөн. Нэг төгрөг зуун мөнгөтэй тэнцэнэ.
2. Монгол Улсын мөнгөн тэмдэгт нь цаасан дэвсгэрт болон зоосон хэлбэртэй байна. Монгол Улсын мөнгөн тэмдэгтийн хэв загварыг Улсын Их Хурал батална."






/ Төв банкны тухай хуулийн 7-р зүйл /




МОНГОЛ УЛСЫН ГҮЙЛГЭЭНД БАЙГАА МӨНГӨН ТЭМДЭГТҮҮД






20 000 төгрөгийн дэвсгэрт



-  Анх хэвлүүлсэн он: 2006
-  Хэмжээ /мм/: 72x150
-  Үндсэн өнгө: Ногоон
-  Нүүрэн талын зураг: Чингис хааны хөрөг
-  Ар талын зураг: Төрийн есөн хөлт цагаан туг

10 000 төгрөгийн дэвсгэрт



-  Анх хэвлүүлсэн он: 1995
-  Хэмжээ /мм/: 72x150
-  Үндсэн өнгө: Улбар шар ба ногоон
-  Нүүрэн талын зураг: Чингис хааны хөрөг
-  Ар талын зураг: Эртний Хархорин хотын дотоод талбайн дүрс














5 000 төгрөгийн дэвсгэрт



1 000 төгрөгийн дэвсгэрт








-  Анх хэвлүүлсэн он: 1994
-  Гүйлгээнд гарсан он: 1995
-  Хэмжээ /мм/: 72x150
-  Үндсэн өнгө: Улбар улаан
-  Нүүрэн талын зураг: Чингис хааны хөрөг
-  Ар талын зураг: Эртний Хархорин хотын дотоод талбайн дүрс

-  Анх хэвлүүлсэн он: 1993
-  Хэмжээ /мм/: 72x150
-  Үндсэн өнгө: Хөх
-  Нүүрэн талын зураг: Чингис хааны хөрөг
-  Ар талын зураг: Гэр тэрэг








500 төгрөгийн дэвсгэрт



-  Анх хэвлүүлсэн он: 1993
-  Хэмжээ /мм/: 70x145
-  Үндсэн өнгө: Шар ногоон ба шар хүрэн
-  Нүүрэн талын зураг: Чингис хааны хөрөг
-  Ар талын зураг: Гэр тэрэг

100 төгрөгийн дэвсгэрт



-  Анх хэвлүүлсэн он: 1993
-  Хэмжээ /мм/: 68x140
-  Үндсэн өнгө: Ягаан хүрэн
-  Нүүрэн талын зураг: Сүхбаатарын хөрөг
-  Ар талын зураг: Адуун сүрэг













50 төгрөгийн дэвсгэрт



20 төгрөгийн дэвсгэрт



-  Анх хэвлүүлсэн он: 1993
-  Хэмжээ /мм/: 66x135
-  Үндсэн өнгө: Хүрэн
-  Нүүрэн талын зураг: Сүхбаатарын хөрөг
-  Ар талын зураг: Адуун сүрэг

-  Анх хэвлүүлсэн он: 1993
-  Хэмжээ /мм/: 64x130
-  Үндсэн өнгө: Хар улаан
-  Нүүрэн талын зураг: Сүхбаатарын хөрөг
-  Ар талын зураг: Адуун сүрэг













10 төгрөгийн дэвсгэрт



5 төгрөгийн дэвсгэрт








-  Анх хэвлүүлсэн он: 1993
-  Хэмжээ /мм/: 61x125
-  Үндсэн өнгө: Хар ногоон
-  Нүүрэн талын зураг: Сүхбаатарын хөрөг
-  Ар талын зураг: Адуун сүрэг

-  Анх хэвлүүлсэн он: 1993
-  Хэмжээ /мм/: 59x120
-  Үндсэн өнгө: Тод улаан
-  Нүүрэн талын зураг: Сүхбаатарын хөрөг
-  Ар талын зураг: Адуун сүрэг



1 төгрөгийн дэвсгэрт



-  Анх хэвлүүлсэн он: 1993
-  Хэмжээ /мм/: 57x115
-  Үндсэн өнгө: Тод хүрэн
-  Нүүрэн талын зураг: Арслан
-  Ар талын зураг: Соёмбо



ЗООСОН ТЭМДЭГТҮҮД



500 төгрөгийн зоосон тэмдэгт
Материал: Cupro-nickel
Диаметр: 22.0 мм
Зузаан: 1.7 мм
Ирмэг: Milled
Цутгуулсан он: 1994 он



200 төгрөгийн зоосон тэмдэгт
Материал: Cupro-nickel
Диаметр: 25.0 мм
Жин: 6.2 грамм
Зузаан: 1.7 мм
Ирмэг: Milled
Цутгуулсан он: 1994 он



100 төгрөгийн зоосон тэмдэгт
Материал: Cupro-nickel
Диаметр: 22.0 мм
Жин: 3.84 грамм
Зузаан: 1.5 мм
Ирмэг: Milled
Цутгуулсан он: 1994 он



50 төгрөгийн зоосон тэмдэгт
Материал: Хөнгөн цагаан
Диаметр: 23.0 мм
Жин: 1.68 грамм
Зузаан: 1.8 мм
Ирмэг: Milled
Цутгуулсан он: 1994 он









20 төгрөгийн зоосон тэмдэгт
Материал: Хөнгөн цагаан
Диаметр: 17.5 мм
Жин: 0.78 грамм
Зузаан: 1.5 мм
Ирмэг: Milled
Цутгуулсан он: 1994 он



Мөнгөн дэвсгэрийг “хүчингүй”-д тооцох нь



Монголбанк нь хуурамч мөнгөн тэмдэгт илрүүлэх, хуучирч муудсан эсвэл хуурамч мөнгөн тэмдэгтийг устгах, хуучирч элэгдсэн төгрөгийн дэвсгэрийг солих ажлыг зохион байгуулдаг. Дараах нөхцөлд Монголбанк мөнгөн дэвсгэрийг “хүчингүй”-д тооцож, шинэ дэвсгэртээр нөхөн олгодоггүй. Үүнд:

-  Дэвсгэрийн гуравны нэгээс илүү хэсэг үгүй болсон
-  Хоёр өөр дэвсгэрийн тасархай наагдсан, нэг дэвсгэрийн хоёр өөр дугаартай хэсэг наагдсаны нэг талынх нь гуравны нэгээс илүү хэсэг үгүй болсон
-  Олон хэсэг болон тасарч, тэдгээрийг эвлүүлэхэд нэг дэвсгэрт мөн биш нь ялгагдахгүй болсон
-  Хуурамч байж болзошгүй
-  Дэвсгэрийн тоо, үсэг, зураг, хэмжээ, өнгө зэрэг бүхэлдээ өөрчлөгдсөн
-  Галд шатаад гуравны хоёроос доошгүй хэсэг үлдсэн



2. Мөнгөний бодлого боловсруулж, хэрэгжүүлэх

Мөнгөний бодлого

Аливаа улс оронд төрөөс эдийн засгийн үндсэн 2 төрлийн бодлогыг авч хэрэгжүүлдэг. Нэг нь иргэд, аж ахуйн нэгжүүдээс цуглуулдаг татварын орлогоор дамжуулж засгийн газраас явуулдаг төсвийн буюу сангийн бодлого юм. Харин нөгөө нь Төв банкнаас явуулдаг мөнгөний бодлого. Энэхүү хоёр бодлого аль аль нь зохистой байхаас гадна, хоорондоо уялдаатай байх нь эдийн засаг тогтвортой хөгжих үндэс болдог.




Төв банкууд мөнгөний бодлогоор дамжуулж мөнгөний нийлүүлэлтэд нөлөөлж, эцсийн дүндээ эдийн засаг дахь үнийн өсөлт буюу инфляцыг нам дор, тогтвортой түвшинд байлгахад анхаардаг. Үнэ тогтвортой байснаар тодорхойгүй байдал арилж, эдийн засаг урт хугацаанд тогтвортой өсөх, улс орон хөгжих нэг суурь нь болж өгдөг юм. Төв банкны мөнгөний бодлогын шийдвэр харьцангуй богино хугацаанд гарах боломжтой ч, үр дүн нь эдийн засагт аажмаар илэрдэг онцлогтой. Жишээ нь, Төв банк бодлогын хүүг өөрчлөх шийдвэрийг гаргаснаас хойш 3-5 улирлын дараа эдийн засагт хамгийн өндөр нөлөөллөө үзүүлдэг, тэрхүү нөлөөлөл нь 1-3 жил ч үргэлжлэх боломжтой байдаг.



Бодлогын хүү

Төв банкуудын санхүүгийн зах зээлтэй харьцдаг нэг гол арга хэрэгсэл нь бодлогын хүү юм. Монголбанкны хувьд ТБҮЦ зэрэг мөнгөний бодлогын хэрэгслүүдэд төлөх хүүг Бодлогын хүү гэж нэрлэдэг. Тухайлбал, арилжааны банкууд 21 хоногийн хугацаатай Төв банкинд мөнгөө хадгалуулаад авах хүү нь Бодлогын хүү юм. Бодлогын хүү нь банк хоорондын захын хүү, Засгийн газрын үнэт цаасны хүү, цаашлаад хадгаламж, зээлийн хүү тогтох суурь болдог зах зээлийн хөтөч хүү юм.

Мөнгөний бодлогын хүүг өөрчлөх, эсвэл хэвээр хадгалах шийдвэрийг Монголбанкны Мөнгөний бодлогын хороо тогтсон хуваарийн дагуу (жилд 4 удаа) хуралдаж гаргадаг.




Арилжааны банкууд Төв банкинд хадгалуулж буй мөнгөн хөрөнгийн хариуд Төв банкнаас төлж буй хүүгийн хувь хэмжээ юм.




Бодлогын хүү эдийн засагт хэрхэн нөлөөлдөг вэ?

Бодлогын хүү өндөр байх тусам арилжааны банкуудын Төв банкинд мөнгөн хөрөнгөө эрсдэлгүй, найдвартай хадгалуулах сонирхол нэмэгддэг. Тэр хэрээр арилжааны зээл гаргах сонирхол нь буурч, улмаар зээлийн хүүгээ нэмэгдүүлдэг. Эсрэгээрээ бодлогын хүү багассан үед арилжааны банкууд дам нөлөөгөөр зээлийн хүүг тодорхой хэмжээгээр бууруулах боломжтой.



Бодлогын хүү – инфляцыг жолоодох арга хэрэгсэл

Бодлогын хүүг нэмэгдүүлэх нь инфляцын хэт өсөлт, эдийн засгийн болзошгүй халалтаас сэргийлэх зорилготой. Харин эдийн засгийн өсөлт саарч байгаа үед бодлогын хүү нь зах зээл дэх мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжих арга хэрэгсэл болдог. Бодлогын хүү өндөр байх нь инфляцын нам дор түвшинд барихад чухал нөлөөтэй. Харин инфляц нэгэнт нам дор төвшинд очиж, эдийн засаг тогтворжсон үед бодлогын хүүг зөөлрүүлэх замаар эдийн засгийн идэвхжлийг хангах боломжтой юм.





Мэдлэгт дусал нэмэр

МӨНГӨНИЙ БОДЛОГЫГ АМЖИЛТТАЙ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ

Мөнгийг үнэ цэнэтэй байлгахын тулд Төв банкнаас явуулж буй мөнгөний бодлого нь олон төрлийн арга хэрэгсэл, хэд хэдэн төвөгтэй суваг, дамжлагыг давах шаардлага гардаг. Мөнгөний бодлогыг амжилттай хэрэгжүүлэхэд дараах 3 зүйл нэн чухал:

1. Мөнгөний бодлогын зорилго тодорхой байх

Мөнгөний бодлогын зорилго тодорхой байх тусмаа тэрхүү зорилго амжилттай биелэхэд дөхөм болдог. Аливаа улс орны мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргах, мөнгөний нийлүүлэлтийг удирдах зэрэг нь маш их эрх мэдэл, үүрэг хариуцлагыг агуулдаг. Иймд зорилгыг аль болох нарийвчлан зааж өгснөөр мөнгөний бодлого хэрэгжүүлэгч институци буюу Төв банкин дээр хэт их эрх мэдэл төвлөрөх, улмаар үүсч болох аливаа эрсдэлээс сэргийлэх боломжтой болно.

2. Мөнгөний бодлогыг боловсруулж хэрэгжүүлэгч Төв банк хараат бус байх

Төв банкны хараат бус байдал алдагдаж, улс төрөөс хэт хамааралтай шийдвэрүүд гарснаар улс орны эдийн засаг өндөр эрсдэлд орсон түүх цөөнгүй. Богино хугацаанд үр дүнгээ өгч сонгогчдод таалагдах улс төрийн шинжтэй шийдвэрүүд нь дунд, урт хугацааны үнийн тогтвортой байдал, эдийн засгийн өсөлтөд ихээхэн сөрөг нөлөөлсөн жишээ ч бий. Тийм ч учраас өнөөдөр дэлхийн олонх улс орон, тэр дундаа эдийн засгийнхаа хөгжлөөр тэргүүлэгч орнуудад Төв банкны хараат бус байдлыг хуулиар онцгойлон баталгаажуулж өгдөг жишиг нэгэнт тогтжээ.

3. Төв банк ил тод байх, олон нийттэй харилцах харилцаа ойлгомжтой байх

Төв банк ил тод, нээлттэй байснаараа нэг талаас мөнгөний бодлого хэрэгжүүлэгч институцийг хянах, улмаар хариуцлагатай ажиллуулах боломж бүрдэнэ. Харин нөгөө талаас мөнгөний бодлогод итгэх итгэлийг нэмэгдүүлэх чухал хөшүүрэг болдог.

Төв банк олон нийттэй идэвхтэй харилцаж, бодит мэдээллийг түгээн тайлбарлах нь мэдээллийн тэгш бус байдлыг бууруулах, зах зээл тодорхой бөгөөд тогтвортой байх, улмаар мөнгөний бодлогын зорилт амжилттай биелэхэд эерэгээр нөлөөлдөг.



Үнийн тогтвортой байдлын ач холбогдол

Инфляц нь эдийн засгийн өсөлт, ядуурал г.м. асуудал шиг үргэлж олны анхаарлын төвд байдаг сэдэв биш бөгөөд үнэ тогтвортой үед “мартагддаг” гэж хэлж болохоор үзүүлэлт. Харин үнэ тогтвортой байхаа больсон цагт л бид ямар чухал зүйл болохыг нь гэнэт ухаарах нь түгээмэл.





Үнэ тогтвортой байна гэдэг нь нийт ард иргэдэд ашигтай зүйл бөгөөд эдийн засаг тогтвортой, үр ашигтай ажиллах суурь хөрс нь болдог. Учир нь бүтээгдэхүүн үйлчилгээний үнийн өөрчлөлт бол худалдан авалт хийж буй хэрэглэгчид, мөнгөө хадгалуулж буй хадгаламж эзэмшигчид, эсвэл хөрөнгө оруулалт хийж буй бизнесийн байгууллагууд гээд хэн бүхэнд шууд нөлөөтэй. Харин үнэ тогтворгүй үед иргэдийн бодит орлого буурах, ядуурал нэмэгдэх, нийгэмд тэгш бус байдал даамжрах г.м. олон сөрөг тал бий болдог.




Мэдлэгт дусал нэмэр

Үнэ тогтворгүй үед юу үүсэх вэ?

 Үнийн өсөлт 231 сая хувьд хүрч, 100 триллион дэвсгэрт гүйлгээнд гаргахад хүрч байсан Зимбабве улсын 2008 оны үйл явдал гипер инфляц иргэдийн худалдан авах чадварт хэрхэн нөлөөлж, эдийн засгийг сүйрүүлж болохыг харуулсан.

 Мөнгөн хуримтлалыг богино хугацаанд үнэ цэнэгүй цаас болгон хувиргах хурдтай үнийн өсөлт нь банк санхүүгийн системийг хэрхэн тогтворгүй болгодгийг 2016 оны байдлаар 40% болон 800%-ийн инфляцтай байсан Аргентин, Венесуель улсын жишээ харуулж байна.

 Инфляц хасах утгатай буюу бүтээгдэхүүний үнэ өсөх биш харин урвугаар буурч, “дефляци”-тай байх үед компаниуд зардлаа бууруулахын тулд хөрөнгө оруулалтаа танах, ажиллах хүчээ цомхотгох замаар эдийн засаг агшдаг болохыг Японы сүүлийн 30 жилийн түүхээс харж болно.

Үнэ тогтворгүй, савлагаатай байхын зовлонг Монголчууд ч туулж үзсэн бөгөөд 90-ээд оны эхэнд инфляц 300% давж, жилийн дотор үнэ 3 дахин өсөхөд иргэдийн хэрэглээ, худалдан авах чадвар, халаасанд байгаа мөнгөнд ихээхэн дарамт учирч байсан.



3. Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэх нь

Монголбанкинд олгогдсон өөр нэг үүрэг, үйл ажиллагааны чиглэл бол Засгийн газрын зуучлагчаар ажиллах явдал юм. Ингэхдээ юун түрүүнд гэрээний дагуу Төрийн сангийн нэгдсэн дансыг Сангийн сайдын хүсэлтээр өөр дээрээ байршуулж, Засгийн газрын төлбөр, түүнтэй холбогдох төлбөр тооцоог гүйцэтгэнэ. Ингэснээр Төрийн сангийн нэгдсэн дансны зардал буурах давуу талтай.

Нөгөө талаас мөн Монголбанк нь Засгийн газраас гаргасан үнэт цаасыг Засгийн газрын хүсэлтээр бусад этгээдэд зуучлан борлуулах ба төрийн мөнгөний бодлогын зорилт, зах зээлийн тухайн үеийн нөхцөл байдалд нийцэж байвал түүнийг худалдан авах, худалдах боломжтой. Гэхдээ энэ үйл ажиллагааг Засгийн газрын шийдвэрээр 2017 оны 10-р сараас хойш явуулаагүй байгаа.





4. Банкны үйл ажиллагаанд хяналт тавих

1. Монголбанк банк байгуулах зөвшөөрөл болон банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, банкны өөрийн хөрөнгө, төлбөрийн чадварыг хангуулах, үйл ажиллагааг нь зохицуулах, албадлагын арга хэмжээ авахтай холбогдсон дүрэм, журам, заавар, аргачлал болон холбогдох бусад шийдвэр гаргаж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллана.
2. Банк байгуулах, үйл ажиллагаа явуулах болон холбогдох бусад зөвшөөрөл олгох, зөвшөөрлийг хүчингүй болгох, банкны удирдлага, зохион байгуулалтын үндсэн зарчмыг тогтоох, хязгаарлалт хийх, шаардлага тавих, хяналт шалгалт хийх, банк, банкны нэгдэлд албадлагын арга хэмжээ авах үйл ажиллагааг холбогдох хуулиар зохицуулан хэрэгжүүлнэ.
3. Зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих замаар санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах зорилгоор зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, татгалзах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, хяналт шалгалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг хуулиар зохицуулна.

**Төв банк нь банкны системд
зохицуулагчийн үүрэг
гүйцэтгэдэг**





5. Үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, зохицуулах

Монголбанк Үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, зохицуулж, хяналт тавина. Үүнд:

1. Үндэсний төлбөрийн системийн бодлого
2. Төлбөрийн системийн хяналтын бодлого
3. Банк хоорондын их дүнтэй гүйлгээний төлбөр тооцоо
4. Банк хоорондын бага дүнтэй гүйлгээний төлбөр тооцоо
5. Төлбөрийн карт








6. Гадаад валютын улсын нөөцийг эзэмшиж, удирдах

Монголбанк эзэмшин, удирдаж байгаа гадаад валютын улсын нөөцийн гадаад төлбөрийг түргэн гүйцэтгэх чадвар, найдвартай байдлыг хангах үүрэгтэй. Зөвхөн эдгээр үүрэг бүрэн биелсэн нөхцөлд гадаад валютын улсын нөөцийг ашиглан санхүүгийн зах зээл дээр арилжаалагдах хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх замаар орлогыг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулна.





-  Монголбанкин дахь гадаад валютын улсын нөөц дараах төрлийн активаас бүрдэнэ:
 - 1) Гадаад орны банк, санхүүгийн байгууллагад хадгалж байгаа мөнгөжсөн алт;
 - 2) Бэлэн ба бэлэн бус хэлбэрээр байгаа чөлөөтэй хөрвөдөг гадаад валют;
 - 3) Чөлөөтэй хөрвөдөг гадаад валютаар төлөгдөх вексель;
 - 4) Гадаад орны Засгийн газар, төв банк, олон улсын санхүүгийн байгууллагаас гаргасан буюу баталгаажуулсан чөлөөтэй хөрвөдөг гадаад валютаар нэрлэсэн, түүгээр төлөгдөх бүх төрлийн үнэт цаас;
 - 5) Олон улсын хэмжээнд гадаад валютын нөөцөд тооцогдох бусад актив.
-  Монголбанк гадаад валютын улсын нөөцийг удирдахдаа гадаад валютын нөөцийн бүрэлдэхүүн хэсгийг харилцан чөлөөтэй хөрвүүлэх, худалдах, худалдан авах үйл ажиллагаа явуулна.
-  Монголбанк чөлөөтэй хөрвөдөг гадаад валют, түүнтэй адилтгах хэрэгслийг төгрөгөөр худалдах, худалдаж авахдаа төгрөгийн тогтвортой байдлыг хангана.
-  Гадаад валютын улсын нөөц нь Улсын Их Хурлаас тогтоосон доод хэмжээнээс багассан эсхүл гадаад валютын бодлогыг хэрэгжүүлэх болон улсын гадаад төлбөр тооцоог шуурхай явуулах боломж алдагдсаныг Монголбанк тодорхойлсон нөхцөлд Монголбанк Засгийн газартай хамтран холбогдох арга хэмжээ авна.



7. Банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах



1. Монголбанк хадгаламж эзэмшигч, харилцагчийн эрх ашгийг хамгаалах, банкны тогтолцооны найдвартай байдлыг бэхжүүлэх зорилгоор банк байгуулах зөвшөөрөл болон банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, банкны өөрийн хөрөнгө, төлбөрийн чадварыг хангуулах, үйл ажиллагааг нь зохицуулах, албадлагын арга хэмжээ авахтай холбогдсон дүрэм, журам, заавар, аргачлал болон холбогдох бусад шийдвэр гаргаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.
2. Хадгаламж эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах зорилгоор Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт тавина.
3. Олон нийтийн санхүү, эдийн засгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх бодлого боловсруулан хэрэгжүүлнэ.



Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх зорилтын хүрээнд иргэд санхүүгийн зах зээлд оролцоходоо оновчтой шийдвэр гаргах мэдлэг, чадварыг нь нэмэгдүүлэх зорилгоор Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх ажлыг дараах зорилтот бүлэгт чиглэн ажиллаж байна.

1. Сургуулийн насанд санхүүгийн мэдлэг олгох;
2. Залуу үед санхүүгийн мэдлэг олгох;
3. Хөдөө орон нутгийн иргэдэд санхүүгийн мэдлэг олгох;
4. Цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр санхүүгийн мэдлэг олгох.



8. Макро зохистой бодлого хэрэгжүүлэх

Монголбанк мөнгөний бодлогын хэрэгжилт болон банк, санхүүгийн тогтолцооны тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг тодорхойлж, үнэлэн түүнээс урьдчилан сэргийлэх, бууруулах зорилгоор макро зохистой бодлогыг боловсруулж, хэрэгжүүлнэ.

Монгол Улсад макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх үндсэн зорилго нь

- i) санхүүгийн тогтвортой байдлыг хангах,
- ii) санхүүгийн системийн дархлааг бэхжүүлэх,
- iii) системийн эрсдэлээс урьдчилсан сэргийлэхэд оршино.

Макро зохистой бодлого нь Монголд төдийгүй олон улсад ч харьцангуй шинэ ойлголт бөгөөд Төв банк эдийн засгийн мөчлөгийг санхүүгийн мөчлөгтэй хамт зохицуулахад тус болдог. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн мөчлөг, санхүүгийн мөчлөгтэй зөрөх үед санхүүгийн тогтвортой байдлыг хангах, **нийгмийн сайн сайхан байдлыг хамгийн өндөр түвшинд байлгахад** зорьдог бодлого, хэрэгслүүд юм.

